

Балар эртний түүх

4-р хичээл

Зөв чиглэл
(Пентатекийн 5-р хичээл)

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

© 2012 Гуравдахь мянган жил үйлчлэл

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Энэхүү материалыг 2007 онд Ийгли ТВ-н Христийн Нэвтрүүлгийн албанд орчуулсан бөгөөд Библийн зарим эшлэлүүдийг Монголын Библийн Нийгэмлэгийн Шинэ Гэрээ ©1990 Эхлэл, номноос зохиогчийн зүгээс Ийгл ТВ-ын Христийн нэвтрүүлгийн албанд өгсөн зөвшөөрлийн дагуу оруулсан.

Библийн бусад эшлэлийг Ариун Бичээс Нийгэмлэгийн Ариун Библи ©2004-ээс авлаа.

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛ нь 1997 онд ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН, АШГИЙН БУС, ХРИСТИТГЭЛИЙН САЙНМЭДЭЭНИЙ ҮЙЛЧЛЭЛ БӨГӨӨД ДАРААХ ТАЛБАНУУДАД ЧИГЛЭДЭГ:

БИБЛИЙН БОЛОВСРОЛЫГ. БҮХ ДЭЛХИЙД. ҮНЭГҮЙ.

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид теологийн мэргэжлийн сургагч багш нар байдаг бөгөөд орчуулагчид нь орон нутгийнхаа унаган хэлтэй теологийн мэдлэгтэй хүмүүс байдгаараа давуу талтай. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл <https://www.thirdmill.org> цахим хуудсаар зочлоорой.

Агуулга

Удиртгал	1
Утга зохиолын бүтэц	1
Чөлөөлөлтийн үер	2
Анхны Гэрээ	2
Мөнхийн Гэрээ	3
Үерээс аврагдсан нь	3
Хуурай газар гарсан нь	3
Ертөнцийн Эзэн Нуахыг санасан нь	4
Шинэ эмх цэгц	4
Нуахын хөвгүүд	5
Бабелийн цамхагийн бүтэлгүйтэл	6
Эх утга	6
Чөлөөлөлтийн үер	7
Холбоосууд	7
Хамаарал	8
Нуахын хөвгүүд	9
Хинаан	9
Зөрчил	10
Хамаарал	10
Бабелийн цамхагын бүтэлгүйтэл	11
Хог	11
Ялалт	12
Хамаарал	13
Орчин үеийн хэрэгжүүлэлт	15
Эхлэл	15
Гэрээ	15
Ялалт	16
Үргэлжлэл	17
Усан баталгаа	17
Сүнслэг дайн	18
Төгсгөл	19
Сүүлчийн эрс эргэлт	19
Сүүлчийн тулалдаан	20
ДҮГНЭЛТ	21
ҮГСИЙН ТАЙЛБАР	23

Балар эртний түүх

4-р хичээл

Зөв чиглэл

УДИРТГАЛ

Сургаал заах ажлаар Украйнд байхдаа би нэг удаа суух ёстой Метроноосоо хариугүй хоцрох шахаж билээ. Буудал руу яаран очиж, шатаар уруудан гүйж, хаалга хаагдахын даваан дээр галт тэрэг рүү үсрэн орсон юм. Би нэлээд удаан явах байсан болохоор амьсгаагаа дарахаар сууж аваад хэдэн минут амарлаа. Харин дараа нь би өөр зүг рүү явж байгаа галт тэргэнд сууснаа гэнэт ойлгосон юм. Дараагийн буудал их хол байсан болохоор эцэс төгсгөлгүй удаан явж хүрсний дараа би буцаад л явлаа. Би маш их оройтох нь тодорхой болсон. Тэр үед би дотроо: “Нөхцөл байдал миний бодсоноор болоогүй ч, ядаж л би одоо зөв зүг рүү явж байна шүү дээ” гэж бодож билээ.

Амьдралын ихэнх салбарт байдал ийм л байдаг шиг санагддаг. Бидний нөхцөл байдал хэзээ төгс байдаггүйн дээр ихэнхдээ төгст дөхдөг ч үгүй. Алхам тутамд л янз бүрийн асуудал, сорилт тулгардаг. Гэхдээ бид буруу замаар явж байхаар ядаж л зөв чиглэлийг барих нь дээр гэдгийг мэддэг.

Бид хичээлээ: “Зөв чиглэл” гэж нэрлэсэн бөгөөд энэ хичээлээр Эхлэл 6-р бүлгийн 11-р ишлэлээс 11-р бүлгийн 9-р ишлэл хүртэл судалж, Нуахын үеийн агуу их үерийн дараа Ертөнцийн Эзэн хүмүүстээ дагах ёстой ямар зам зааж өгснийг олж мэднэ. Балар эртний түүхийн энэ бүлгүүдээс Мөшэх Израйльчуудад мөрдөх чиглэлийг нь тодорхой зааж өгснийг үзнэ. Израйльчууд үүнийг л хүсч байсан гэж хэлж бид чадахгүй ч Ертөнцийн Эзэн тэднийг агуу ерөөл рүү аваачихаар урьдчилан төлөвлөсөн юм. Бид ч тийм чиглэлийг дагах хэрэгтэй учраас балар эртний түүхийн энэ хэсэг Христэд итгэгчдэд маш чухал.

Эхлэлийн 6-р бүлгийн 9-өөс 11-р бүлгийн 9-р ишлэлийг бид гурван хэсэгт хуваан судална. Нэгд, энэ бүлгүүдийн утга зохиолын бүтцийг судална. Хоёрт, Мөшэх үүнийг яагаад Израйльчуудад зориулан бичсэнийг ойлгосноор эх утгыг нь судална. Гуравт, сурснаа амьдралдаа яаж хэрэгжүүлийг мэдэхийн тулд Шинэ Гэрээг удирдлага болгоно. Эдгээр бүлгийн утга зохиолын бүтцийг судлахаас хичээлээ эхэлье.

УТГА ЗОХИОЛЫН БҮТЭЦ

Эхлэл 6-р бүлгийн 9-өөс 11-ийн 9-р ишлэл бол балар эртний түүхийн томоохон хэсэг бөгөөд энэ хэсгийг хэдэн өөр аргаар тоймлож болно. Бид зорилгынхоо дагуу энэ бүлгүүдийг хоёр үндсэн хэсэгт хуваасан. Эхний хэсэгт 6-р бүлгийн 9-өөс 9-р бүлгийн 17-р ишлэл орох ба бид энэ хэсгийг “Чөлөөлөлтийн үер” гэж хэрлэсэн. Мөшэх энэ хэсэгт Нуахын үеийн үерийн тухай бичсэн. Энэ эхийн хоёр

дахь хэсэгт Эхлэлийн 9-р бүлгийн 18-аас 11-р бүлгийн 9-р ишлэл орох бөгөөд “Шинэ эмх цэгц” гэж нэрлэсэн. Энэ бүлэгт үерийн дараах хэдэн шийдвэрлэх үйл явдлыг өгүүлдэг бөгөөд тэдгээр үйл явдал үерийн дараах дэлхийн өнгө төрхийг тодорхойлсон. Энэ хэсгийн утга зохиолын бүтцийг илүү ойлгохын тулд бид энэ үндсэн хоёр хэсгийг хоёуланг нь үзнэ. Эхлээд Нуахын үеийн үерийн тухай Мөшэхийн бичсэн түүхийн бүтцийг судалъя.

ЧӨЛӨӨЛӨЛТИЙН ҮЕР

Нуахын үерийн түүх харьцангуй тодорхой утга зохиолын бүтэцтэйг хэд хэдэн тайлбарлагч сүүлийн жилүүдэд ажиглажээ. Энэ бүтцийг хэд хэдэн аргаар тодорхойлон өгүүлэх боломжтой ч энэ хичээлээрээ бид эдгээр бүлэг хэрхэн тэгш хэмт, таван үе шаттай сэтгэл хөлөлгөсөн үйл явдлыг дүрсэлдгийг үзүүлнэ.

Анхны Гэрээ

Энэ хүүрнэлийн эхний хэсэг Эхлэлийн 6-р бүлгийн 9-22 ишлэлд гарах ба бид үүнийг Нуахтай байгуулсан Ертөнцийн Эзэний анхны гэрээ гэж нэрлэсэн. Муу муухай болсон хүн төрөлхтний дотроос Нуах зөв шударга хүн байсныг энд Мөшэх тэмдэглэсэн. Нуахтэй Ертөнцийн Эзэн ярьж, хүмүүсийг яагаад устгах болсноо илчилсэн. Эхлэл 6:13-т:

Ертөнцийн Эзэн Нуахад хандан: “Хүн төрөлхтөн хаа сайгүй бие биеэ хүчирхийлэх болсон учраас тэднийг би энэ дэлхийтэй хамт устгахаар бат шийдлээ” гэв (Эхлэл 6:13).

Мөн энэ хэсэгт Ертөнцийн Эзэн нэг хүнийг гэрийнхэнтэй нь, нэрлэвэл зөв шударга Нуахыг авран, бүхнийг эхнээс нь эхлэх гэж байгааг өгүүлдэг. Нуахыг зорилгодоо итгүүлэхийн тулд Ертөнцийн Эзэн анхны гэрээгээ байгуулсан. Эхлэл 6-р бүлгийн 17, 18-р ишлэлд Ертөнцийн Эзэн Нуахад:

Энэ дэлхийд байгаа юм болгон устах болно. Харин би чамтай нэг гэрээ тогтооно. Тиймээс чи болон чиний эхнэр, хөвгүүд, тэдний гэр бүлийнхэн тэрхүү усан онгоцонд хоргодон амьд гарна (Эхлэл 6:17-18).

Үерийн тухай өгүүлэмжийн эхэнд Ертөнцийн Эзэн гэрээ байгуулан, Нуахыг гэрийнхэнтэй нь аврахаа тангараглажээ. Энэ гэрээ Нуахын авралыг баталгаажуулж, үерийн дараах шинэ хүн төрөлхтний тэргүүн болгосон.

Ертөнцийн Эзэний Нуахтай байгуулсан анхны гэрээг онцолсноор үерийн түүх эхэлдгийг үзсэн бол одоо энэ эхний хэсэгтэй тэнцдэг, үйл явдлын сүүлчийн хэсгийг 8-р бүлгийн 20-иос 9-р бүлгийн 17-р ишлэлээс үзье. Энэ хэсгийг Ертөнцийн Эзэний Нуахтай байгуулсан мөнхийн гэрээ гэж нэрлэсэн.

Мөнхийн Гэрээ

Ертөнцийн Эзэн үерийн дараа Нуахтай дахин ярьж, өөр гэрээ байгуулсан тухай энэ хэсэгт өгүүлдэг нь гарчигт туссан байгаа. Ертөнцийн Эзэн хүн төрөлхтөнд боломж олгон дэлхийд шинэ эмх цэгц тогтоосон. Эхлэлийн 8-р бүлгийн 22-р ишлэлд:

Харин энэ дэлхий сөнөн сөнөглөө
үр тарих болон ургац хураах хоёр улирал,
өвлийн хүйтэн ба зуны халуун улирал,
өдөр ба шөнөтэйгөө
байг гэж шийдлээ (Эхлэл 8:22).

Энэ шинэ чиглэлийн эргэлзээгүйг батлахын тулд Ертөнцийн Эзэн Нуахтай хоёр дахь гэрээгээ байгуулсныг үерийн тухай хүүрнэлийн төгсгөл буюу Эхлэл 9: 11-15-аас уншиж болно:

Сонсогтун. Үүнээс хойш хүн төрөлхтөн хэзээ ч үерийн усанд тэр аяараа живэхгүй бөгөөд газар дэлхий дахин усан галавт сөнөхгүй. Би энэ гэрээг чамтай болон чиний хамт байгаа бүх хүнтэй тогтооно... Миний тогтоосон гэрээний бэлэг тэмдэг нь тэнгэрийн үүлэнд татах солонго юм. Ийнхүү би хур борооны дараа тэнгэрийн үүлэнд солонго татуулахдаа хүн төрөлхтөн болон амьд амьтан бүхэнтэй тогтоосон мөнхийн гэрээгээ санана (Эхлэл 9:11-15).

Дэлхий дахин хэзээ ч үерт автан устахгүй гэсэн гэрээний амлалтаар, Ертөнцийн Эзэн амлалтаа хэзээ ч мартаггүйн баттай тэмдэг болгон үүлэн дунд солонго татуулснаар Нуахын үерийн үйл явдал дуусч байна. Балар эртний түүхэнд Нуах асар чухал болохын энэ төгсгөлийн гэрээний амлалт харуулж байна. Тэрбээр ирээдүйн бүх үеийнхэнд хамаатай гэрээний зуучлагч байсан.

Үерийн тухай хүүрнэлийн эхний болон сүүлчийн хэсгийг санангаа дотоод хэсгүүдийг нь судалж үзье. Ертөнцийн Эзэний эхний гэрээнээс дунд хэсгийн гурван үндсэн үе шатыг дамжин сүүлийн гэрээний шинэ эмх цэгцэд хүрдэг.

Үерээс аврагдсан нь

Энэ хүүрнэлийн хоёр дахь үе шат 7-р бүлгийн 1-ээс 16-р ишлэлд гарах бөгөөд энэ хэсгийг “Нуах үерээс аврагдсан нь” гэж нэрлэсэн. Энэ хэсэг арай хялбархан бүтэцтэй. Нуах хөлөг онгоц бэлэн болгож бүх төрлийн амьтдыг дотор нь оруулсан. Үерийн ус газар дэлхийд зад тавьсан ч Нуах гэр бүлийнхэнтэйгээ, авчирсан амьтадтайгаа хөлөг онгоцонд ороод аюулгүй байлаа.

Хуурай газар гарсан нь

Нуахын үерийн түүхийн дөрөв дэх хэсэг хоёр дахьтайгаа гайхалтай харалдаа зохиомжтой. “Нуах хуурай газарт гарсан” тухай энэ түүх Эхлэл 8:6-19-р ишлэлд бий. Үерийн ус татарч эхлэхэд Нуах хөлөг онгоцноос гарахын тулд хуурай газрын мөрөөсөл болж байсан. Хэсэг хүлээсний дараа хуурай газар цухуйж, Ертөнцийн Эзэн өмнө нь Нуахыг хөлөг онгоцонд ор гэж тушааж байсан шигээ тэндээс гарахыг тушаасан.

Ертөнцийн Эзэн Нуахыг санасан нь

Одоо бүгдээрээ энэ хүүрнэлийн төв хэсэг буюу шийдвэрлэх үеийг Эхлэл 7-р бүлгийн 17-оос 8-ийн 5-р ишлэлээс харья. Бид энэ хэсгийг “Ертөнцийн Эзэн Нуахыг санасан нь” гэж нэрлэсэн. Догшрон ширүүсэх үерийн ус дэлхий дээрх амьтай голтой бүхнийг устгаж байгааг дүрсэлснээр энэ хэсэг эхэлдэг бол үерийн ус татарч эхэлснээр дуусдаг.

Энэ хэсгийн гол цөм бол Ертөнцийн Эзэн яагаад догшин үерийг номхруулсан тухайх энгийн атлаа гүн утгатай өгүүлбэр юм. Эхлэлийн 8-р бүлгийн 1-р ишлэлд, ид ширүүн бороо орж байхад:

Ертөнцийн Эзэн Нуах болон түүний хамт онгоцонд байгаа бүх хүн амьтныг санан дурсаж өрөвдөхдөө салхи үлээлгэхэд үерийн ус татарч эхлэв (Эхлэл 8:1).

Ертөнцийн Эзэн агуу өршөөлөөрөө, Нуахтай байгуулсан гэрээгээ болон түүнтэй хамт байгаа хүмүүсийг мартаагүй. Тэрбээр хөлөг онгоцонд байсан хүмүүсийг өрөвдөн догшин үерийг намжаасан.

Нуахын үерийн түүхийг тоймлосноор уг түүхийн гол зорилгыг нь мэдэж авна. Мөшэх үерийн түүхийг чөлөөлөлтийн түүх болгон бичсэн. Хэдийгээр хорон хэрцгий хүмүүс шийтгүүлсэн ч гол нь Ертөнцийн Эзэн Нуахаар дамжуулан хүн төрөлхтөнд агуу ивээлээр дүүрэн дэлхий өгснийг Мөшэх харуулахыг хүссэн.

Эхлэл 6-р бүлгийн 9-өөс 11-р бүлгийн 9-р ишлэлийн эхний хэсгийг бид судалсан бол одоо “Шинэ эмх цэгц” гэж нэрлэсэн хоёр дахь гол хэсгийг Эхлэл 9-р бүлгийн 18-аас 11-р бүлгийн 9-р ишлэлээс судалъя.

Шинэ эмх цэгц

Шинэ эмх цэгцийн талаар бичсэн 9-11-р бүлэг үндсэн хоёр хэсэгтэй. Нэгд, Эхлэл 9-р бүлгийн 18-аас 10-ийн 32-р ишлэлд Нуахын хөвгүүдийн талаар бичжээ. Хоёрт, Эхлэл 11-р бүлгийн 1-9-р ишлэлд Вавилон хотын сүйрлийн талаар өгүүлдэг. Эхэндээ энэ хэсгүүд хоорондоо холбоогүй мэт санагдаж болох ч үнэндээ бол дэлхийн шинэ эмх цэгцийн загварыг хамтран бүтээдгийг бид харах болно. Эдгээр нь тэр үеэс хойших дэлхийн түүхийн гол шинжийг дэлгэн харуулдаг. Эхлээд Нуахын хөвгүүдийн тухай болон тэд шинэхэн эмхлэгдсэн дэлхийн дүр төрх бүрдэхэд яаж нөлөөлснийг судалъя.

Нуахын хөвгүүд

Эхлэлийн 9-10-р бүлэг дэх Нуахын хөвгүүдийн түүх нэг гарчиг болон хоёр үндсэн хэсгээс тогтдог. 9-р бүлгийн 18-19-р ишлэл дэхь гарчиг өгүүлбэрүүд нь Эхлэлийн энэ хэсэгт Нуахын гурван хүүгийн тухай, тэд дэлхийгээр хэрхэн тархсан тухай гарахыг заадаг.

Нуахын хөвгүүдийн түүх гарчиг өгүүбэрүүдтэй зохицсон хоёр үндсэн хэсэгтэй. Нэгдүгээрт, 9-р бүлгийн 2-29-р ишлэлд хөвгүүдийн хоорондын ялгааг дэлгэн тавьсан. Харин хоёрдугаарт, 10: 1-32-р ишлэлд Нуахын хөвгүүд болон тэдний үр удам тархан суурьшсан тухай өгүүлдэг. Энэ хоёр хэсгийг тус тусад нь ярилцах нь зүйтэй.

9-р бүлгийн 20-29-р ишлэл бол Хамын хүү Хинаан хараагддаг тухай өгүүлдэг олон хүний мэдэх хэсэг юм. Мөшэх Эхлэлийн 9: 42-27-д ийнхүү бичсэн:

Дараа нь Нуахын согтуу гарч босоод, отгон хүү Хам нь түүнийг дооглосныг мэдээд хэлсэн нь: Хам чиний хүү Хинааныг би хараана! ... гэв. Тэрээр мөн: “Харин дээдийн дээд Ертөнцийн Мөнх Эзэн маань Шээм чамайг ерөөх болтугай! Ертөнцийн Эзэний хүчээр Эффээтийн удам өнөр өтгөн болтугай... (Эхлэл 9:24-27).

Өөрөөр хэлбэл Нуахын үр удмынхны дунд юунаас болж ялгаа гарсныг энд мэдүүлжээ. Хамын хүү Хинааныг Нуах хараан ах нарынхаа боолын боол болно гэсэн байна. Харин өөрт нь хүндэтгэлтэй хандсан учраас Шээм, Эффээт гэдэг хоёр хүүгээ Нуах ерөөжээ.

Хүн төрөлхтөн тэр чигээрээ Нуахын гурван хүүгээс үүссэн учир үерийн дараах шинэ эмх цэгцийг дүрсэлсэн хэсэгтээ Мөшэх энэ түүхийг оруулсан. Библийн түүхэн дэх тэр үеэс хойших хүний харилцааны явц энд гарсан ялгаанаас хамаарсан. Нуахын хөвгүүдийн хооронд ялгаа гарсан нь 10-р бүлэгт буюу тэдний тархан суурьшсан тухай хэсэгт нотлогддог. Нуахын бүр хожим хойчийн үр удмын тухай Эхлэл 10-р бүлэгт Мөшэх бичихдээ Хам, Шээм, Эффээт гурвын удмынхан дэлхийн хаана хаана суурьшсан талаар энгийн жагсаал гаргасан. Эхлэл 10-р бүлгээс харвал Эффээтийнхэн Хинаан нутгийн хойд, зүүн болон баруун хойд хэсэгт суужээ. Цөөхөн тохиолдлыг эс тооцвол Хамынхан Хойд Африк руу нүүдэллэж, Хамын онцгой хүү Хинаан Ертөнцийн Эзэний Израйльд амласан Хинаан нутагт суусан. Шээмийнхэн буюу Семит хүмүүс Арабын хойгийн ихэнх нутгийг эзэмшсэн.

Эхлэлийн 10-р бүлэгт нүүдлийн зөвхөн ерөнхий загварыг л сонгон авч харуулжээ. Гэвч үерийн дараах шинэ эмх цэгц дэхь хүмүүсийн харилцааг тодорхойлсон удаан хугацааны загвараа тайлбарлахад нь энэ ерөнхий загвар Мөшэхэд хангалттай байсан.

Эхлэл 9, 10-р бүлэг дэх Нуахын хөвгүүдийн тухайх хэсгийн утга зохиолын бүтцийг бид судаллаа. Харин одоо “Үерийн дараах шинэ эмх цэгц”-ийн хоёр дахь хэсэг болох Вавилон хот дарагдсан тухайг түүхийг 11-р бүлгийн 1-ээс 9-р ишлэлээс судалъя.

Бабелийн цамхагийн бүтэлгүйтэл

Вавилоны цамхагийн түүх тэгш хэмт, сэтгэл хөдөлгөм таван үе шаттай. 1-2-р ишлэл дэх эхний үе шат хүн төрөлхтний ихэнх хамт байгаагаар эхэлдэг. Гэвч эрс ялгаатай нь, Ертөнцийн Эзэн хүн төрөлхтний хэл яриаг будлиулж, дэлхийгээр нэг тараасан тухай өгүүлдэг 8, 9-р ишлэлээр энэ өгүүлэмж дуусдаг. Нэг хэлтэй, хамтдаа байсан хүн төрөлхтөн хэрхэн олон хэлтэй болж тарж бутрав? Юу болсныг дундах хэсэг тайлбарладаг.

3, 4-р ишлэл дэхь хоёр дахь үе шатанд хүмүүсийн төлөвлөгөөний талаар өгүүлдэг. Тэд алдар нэрээ үүрд дуурсгах, дийлдэшгүй хүчирхэг болохын тулд тэнгэрт тулам агуу цамхагтай хот босгох болсон. Гэвч 6, 7-р ишлэл дэх дөрөв дэх үе шатанд Ертөнцийн Эзэний төлөвлөгөө хүмүүсийн төлөвлөгөөний эсрэг буйг мэдүүлжээ. Ертөнцийн Эзэн их цэргээ дуудан хүмүүсийн хэл яриаг будлиулж, хот болон цамхаг барих ажлыг зогсоолгохоор илгээсэн.

Энэ түүхийн шийдвэрлэх үе бол 5-р ишлэл дэх Ертөнцийн Эзэн хот, цамхагийг шинжлэн үзсэн явдал юм. Ертөнцийн Эзэн хотыг болон бардам хүмүүсийг нь хараад Бабел хотыг үгүй хийхээр шийдсэн.

Тэгэхээр Мөшэхийн бичсэнээс харахад үерийн дараа амьдрал бас тийм ч сайхан байгаагүй. Харин шинэ эмх цэгцийн үед янз бүрийн бүлэг хүмүүсийн хоорондох ярвигтай харилцаа бий болсныг Нуахын хөвгүүдийн тухай түүх харуулдаг. Мөн Ертөнцийн Эзэнийг бүр илүү басамжилсан тухай, Ертөнцийн Эзэн тэднийг ялан дийлсэн тухай энэ хэсэгт гарсан. Шинэ эмх цэгцийн энэ бүтэц бидэнд хачин санагдаж болох ч, Мөшэх энэ бүхнийг анх зориулан бичсэн Израйльчуудын амьдралд бол их ойрхон байсан юм.

Бид Эхлэлийн 6-р бүлгийн 9-өөс 11-ийн 9-р ишлэл хүрэлх хэсгийн утга зохиолын бүтцийг судалсан бол одоо хоёр дахь асуултандаа орьё. Үер хийгээд дараа нь тогтсон шинэ эмх журмын тухайх энэ баримтыг Мөшэх яагаад бичсэн бэ? Амласан нутаг руу дагуулж явсан Израйльчууддаа тэрбээр юу ойлгуулах гэсэн бэ?

ЭХ УТГА

Израйльчуудад балар эртний түүхэн баримтыг мэдүүлэхийн тулд Мөшэх үер, шинэ эмх цэгцийн тухай бичсэн нь ойлгомжтой гэж хэлэх хэрэггүй. Их л шилж сонгон, тодорхой сэдвүүд рүү чиглэн бичсэнийг нь харахад тэрбээр нэгийг бодсон нь илт. Мөшэх зөвхөн өнгөрснийг мэдүүлэхээр биш, харин тухайн үедээ Израйльчуудыг удирдахаар бичсэн.

Бид Мөшэхийн зорилгыг тайлахдаа Эхлэл 6-р бүлгийн 9-өөс 11-р бүлгийн 9-р ишлэлийн гурван хэсгийн судална. Нэгд, үерийн тухай хүүрнэлийн эх утгыг судална. Дараа нь Нуахын хөвгүүдэд тохиолдсон явдлыг шинжилж, эцэст нь балар эртний түүхийн сүүлчийн хэсэг болох Вавилоны ялагдлын түүхийн эх утга юу болохыг анхаарна. Эхлээд Мөшэх Нуахын үерийн түүхийг тэр үеийнхээ Израйльчуудтай хэрхэн холбосныг харъя.

ЧӨЛӨӨЛӨЛТИЙН ҮЕР

Мөшэх үерийн тухай хүүрнэлийг яаж ашигласныг олж харахын тулд үйл явдлын хоёр талыг судалъя. Нэгд, үерийг Египетээс гарсан их нүүдэлтэй хэрхэн холбосон, хоёрт, үүгээрээ юуг ойлгуулахыг зорьсоныг судална. Мөшэх Нуахыг өөрийнхөө амьдрал, үйлчлэлтэй төстэйгөөр дүрслэн үерийн үеийг өөрийнхөө үетэй холбожээ. Нуах, Мөшэх хоёрын амьдралд ялгаатай зүйл мэдээж олон байсныг анхаарах нь зүйтэй. Гэхдээ Мөшэх Нуахыг дүрслэхдээ түүнийг өөрийнхөө өмнөх хүн, урьдчилсан шинж тэмдэг гэж Израйльчууддаа ойлгуулахыг зорьсон юм.

Холбоосууд

Нуах Мөшэх хоёрт доод тал нь найман чухал ижил төстэй зүйл байдаг.

1. Нэгд, Мөшэх хүчирхийллийн талаар бичихдээ Нуахыг өөртэйгөө холбосон. Эхлэлийн 6-р бүлгийн 13-р ишлэлд дэлхий хүчирхийллээр дүүрсэн учир усан галав юүлсэн гэж бичсэнийг та санаж буй байх. Гэтэл бас Мөшэхийг уриалахын өмнө Египетчүүд Израйльчуудыг ихэд харгисладаг байсныг Чөлөөгдсөн нь 1-2-р бүлэгт бичсэн. Израйль хүмүүс харгислуулан зовж байсан учир Мөшэх Египетээс тэднийг чөлөөлсөн юм. Тиймээс хүчирхийллээс чөлөөлөх нь Нуахын ч, Мөшэхийн ч үүрэг байжээ.

2. Хоёрт Мөшэх “хөлөг онгоц” гэдэг үгээр холбосон. Эхлэл 6-9-р ишлэлд гардаг Нуахын хөлөг онгоцыг Еврейгээр “тева” гэсэн байдаг. Үнэхээр сонирхолтой нь “тева” гэдэг үгийг Мөшэх дахиад зөвхөн Египетээс гарсан нь 2-р бүлгийн 3, 5-д л хэрэглэсэн. Ээж нь түүнийг хөлөг онгоц буюу “тева”-д оруулж байгаа юм шиг сагсанд тавьсаныг тэрбээр бичсэн. Хэдийгээр Нуахын хөлөг онгоц аварга том, Мөшэхийнх өчүүхэн жижиг байсан ч тэр өөрөө ч, Нуах ч их усны аюулаас нэг төрлийн хөлөг онгоц “тева”-гаар аврагдсан болохыг харуулжээ.

3. Гуравдугаарт, Ертөнцийн Эзэний гэрээ Нуахыг Мөшэхийн өмнөх хүн болгодог. Нуах нийт хүн төрөлхтнийг төлөөлөн Ертөнцийн Эзэнтэй гэрээ байгуулсаныг бид Эхлэл 6-р бүлгийн 18, 9-р бүлгийн 11-17-р ишлэлээс уншдаг. Тэгтэл бас Израйльчуудын төлөөх Мөшэхийн гол үйлчлэл Ертөнцийн Эзэний гэрээний зууч болох байсан юм. Ертөнцийн Эзэн Синай ууланд тогтоон өгсөн онцгой гэрээнийхээ дагуу Израйльчуудыг удирдуулахаар Мөшэхийг сонгосон тухай Египетээс гарсан нь номын 19-24-р бүлгүүдэд тодорхой тайлбарладаг.

4. Дөрөвдүгээрт, усанд автуулан шийтгэсэн тухай баримт энэ хоёр хүнийг мөн холбодог. Эхлэл 6-9-р бүлэгт Ертөнцийн Эзэн үерийн их уснаас Нуахыг гэрийнхэнтэй нь аварч, дэлхий дээрх хорон муу хүмүүсийг устгасан тухай өгүүлдэг. Үүнтэй их адилаар, Египетээс гарсан нь 13-15-р бүлэгт Мөшэх Улаан тэнгис дундуур Израйльчуудыг дагуулан гарсан бөгөөд уг тэнгист Египетийн эзэрхэгчдийн их цэрэг сүйрсэн тухай бичиж үлдээсэн.

5. Тавдугаарт, Нуахын үед ч, Мөшэхийн үед ч Ертөнцийн Эзэн их усыг татруулахаар салхи үлээлгэсэн. Ертөнцийн Эзэн галав юүлсэн их усыг татруулахыг

тулд салхи илгээсэн тухай Эхлэлийн 8-р бүлгийн 1-р ишлэлд гардаг. Үүний адил Египетээс гарсан нь 14-р бүлгийн 21-д Улаан тэнгис дээр: “Мөнхийн Эзэн дорнын хүчит салхиар тэнгисийн усыг ухраасан” гэсэн.

6. Зургадугаарт, амьтдыг чухалчилснаараа төстэй. Ертөнцийн Эзэн амьтдыг онгоцонд оруул гэж Нуахад тушаасныг Эхлэл 6-р бүлгийн 19-р ишлэл өгүүлдэг. Израйльчууд Египетээс мал сүрэг олонтой гарсан тухай “Египетээс гарсан нь” номонд 4-өөс цөөнгүй дурддаг. Шинэ дэлхийд амьтдыг аваачихыг Нуахад тушаасан шигээ амласан нутаг руу ч амьтдыг аваачих хэрэгтэйг Мөшэхэд Ертөнцийн Эзэн тушаасан.

7. Долоод, Ертөнцийн Эзэн эргэн санасан тухай хэсэг Нуах, Мөшэх хоёыг холбодог. Үерийн ус догшрон байхад Ертөнцийн Эзэн Нуахыг эргэн санасан учраас салхи үлээлгэсэн тухай Эхлэлийн 8-р бүлгийн 1-р ишлэлд байдаг. Ертөнцийн Эзэн их үерээс бүрэн бүтэн гаргана гэж Нуахтай гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээгээ мартаагүй. Үүнтэй тун адилаар Ертөнцийн Эзэн гэрээгээ санаж байгаа учир Израйльчуудыг Египетээс ангижруулна гэж Мөшэхэд тунхагласан. Ертөнцийн Эзэний Мөшэхэд хэлсэн үгийг Египетээс гарсан нь 6:5-аас харвал:

Би Египетчүүдэд боолчлогдож байгаа Израйльчуудын уй гашууг сонсож, гэрээгээ саналаа (Чөлөөлөгдсөн нь 6:5).

Үерийн үе болон Египетээс гарах үед Ертөнцийн Эзэний дурсамж амин чухал үүрэг гүйцэтгэсэн.

8. Эцэст нь байгалийг ивээсэн нь Нуах, Мөшэх хоёрыг холбодог. Ертөнцийн Эзэний амласан, хүн төрөлхтөнд үр өгөөжөө хайрлах бат бэх, өнө удаан байгалийн хуультай шинэ дэлхийд Нуах хүмүүсийг авчирсан. Үүний адилаар амласан нутгийн байгаль хувиршгүй бөгөөд ашиг тустай байна гэж Мөшэх Израйльчуудад хэлдэг.

Нуах, Мөшэх хоёрын хоорондын эдгээр холбоог санангаа дээр дурдсан адил төстэй зүйлсээр Израйльчуудад юу ойлгуулах гэснийг үзэцгээе. Мөшэх яагаад энэ бүгдийг холбон үзсэн бэ?

Хамаарал

Энэ эхийн цаад утгыг ойлгохын тулд бид Израйль хүмүүс Мөшэхийг ширүүн эсэргүүцэж, эрх мэдэлд нь болон Египетээс дагуулан гаргасан, Хинааныг булаан эзлэхээр яваа зэрэг нь зөв эсэхэд эргэлзэж байсныг санах хэрэгтэй. Үйлчлэлд нь тулгарсан эдгээр бэрхшээлийг шийдэх үүднээс Мөшэх тэдгээр уялдаа холбоог гарган тавьсан.

Ертөнцийн Эзэн хүн төрөлхтнийг эртний аймшигт хүчирхийллээс усан галаваар чөлөөлж, агуу их ивээлээр дүүрэн шинэ дэлхийд хүн төрөлхтнийг дахин бий болгохдоо Нуахыг ашигласан. Үүнтэй яг адил Ертөнцийн Эзэн Израйльчуудыг Египетийн аймшигт харгислалаас чөлөөлж, амласан нутагтаа аваачихын тулд Мөшэхийг сонгосон. Израйлийн төлөөх Мөшэхийн төлөвлөгөө усан галавын төлөвлөгөөтэй их адилхан байсан учир Ертөнцийн Эзэнээс ирснийг нь хэн ч шууд няцааж чадахгүй байв.

Чөлөөлөлтийн усан галавын эх утга юу болохыг бид үзсэн бол одоо Нуахын

хөвгүүдийн талаар Мөшэх юу гэж бичсэнийг Эхлэл 9-р бүлгийн 18-аас 10-р бүлгийн 32-р ишлэлээс харъя.

НУАХЫН ХӨВГҮҮД

Балар эртний түүхэнд Мөшэх яагаад энэ түүхийг багтаав? Ямар зорилгоор Израйльчуудын сонорт энэ түүхийг толилуулсан бэ? Мөшэхийн бичсэн түүхийн энэ хэсгийг судлахын тулд бид: нэгд, Хинааныг онцолсныг нь, хоёрт, зөрчилдөөний сэдвийг, гуравт эдгээр баримтаар Израйльчуудад юуг ойлгуулах гэснийг үзнэ. Эхлээд Хинааныг хэрхэн онцолсныг авч үзье.

Хинаан

Нуах согтуу унтаж байгаад сэрснийхээ дараа Хам өөрийг нь доромжилж, Шээм, Эфээт хоёр хүндэлснийг олж мэддэгийг та санаж байгаа биз ээ. Хоёр хүүгээ ерөөсөн шигээ, зөвхөн Хамд л уурлаж хараах нь зүйд нийцэх мэт санагддаг. Гэвч огт өөр зүйл болсон. Нуахын хэлсэн үгийг Эхлэл 9-р бүлэг 25-27-р ишлэлээс харъя:

Ханааныг би хараана. Шээм, Эфээт нарын боолын боол болог. Харин дээдийн дээд Мөнхийн Эзэн Шээмийг ерөөх болтугай! Хинаан Шээмийн боол болог. Ертөнцийн Эзэний хүчээр Эфээтийн удам өнөр өтгөн болж, Шээмийн удамтай нэг ам бүлд багтан амьдарч, Хинааны удмыг боол болгосугай” гэв” (Эхлэл 9:25-27).

Энэ хэсгээс харахад Шээм, Эфээт нар сайн үйлсийнхээ тохирох шагналыг авсан бол энд Хамын нэр дурдагдсан ч үгүй. Түүний оронд Хинаан гэдэг хүү нь Нуахын хараалыг хүртжээ.

Энэ түүхийг сайтар ажиглавал Хам ах дүү хоёроосоо өөр үүрэг гүйцэтгэж байгаа нь мэдэгдэнэ. Товчхондоо Хинааны аав байсан гэдгээс өөр, илүүтэй ач холбогдол түүнд алга байна. Мөшэх өгүүлэмждээ Хамын тухай юу гэж бичсэнийг харъя. 9-р бүлгийн 18-р ишлэлд:

Нуахын хамт амьд үлдсэн хөвгүүд нь Шээм, Хам, Эфээт нар юм. (Хам нь хожим Хинаан гэдэг хүүтэй.) (Эхлэл 9:18).

9-р бүлгийн 22-р ишлэлд ч түүнийг мөн адил тодотгосон. Энд:

Хинааны эцэг Хам эцгийнхээ нүцгэн хэвтээг харсан (Эхлэл 9:22).

Хам энэ түүхэнд уусан алга болж, түүний хүү Хинаан Шээм, Эфээт хоёртой зэрэгцэн, орыг нь эзэлсэн нь олон талаар харагддаг.

Мөшэх Хинааныг онцгой анхаарсныг санангаа түүний анхаарлаа хандуулсан хоёр дахь зүйл болох үерийн дараах зөрчлийг авч үзье. Энэ нь Нуахын хөвгүүдийн

талаарх түүхээс харагддаг.

Зөрчил

Мөшэх Нуахын хөвгүүдийн талаар бичихдээ зөрчлийн сэдэвт голлон анхаарчээ. Энэ сэдвийг орхивол энэ түүхийн хамгийн чухал талыг орхилоо гэсэн үг. Зөрчлийн үзэл санаа Эхлэл 9:25-27-оос мөн харагддаг. Энд:

Хинааныг би хараана. Шээм, Эфээт нарын боолын боол болог. Харин дээдийн дээд Мөнхийн Эзэн Шээмийг ерөөх болтугай! Хинаан Шээмийн боол болог. Ертөнцийн Эзэний хүчээр Эфээтийн удам өнөр өтгөн болж, Шээмийн удамтай нэг ам бүлд багтан амьдарч, Хинааны удмыг боол болгосугай” гэв (Эхлэл 9:25-27).

Хинаан хараагдсаныг Мөшэх энэ хэсэгт гурван удаа давтахдаа зөрчил зайлшгүй болохыг онцлон тэмдэглэсэн. 25-р ишлэлд Хинаан “боолын боол” буюу байж болох хамгийн дорд боол байхаар хараагдсаныг сонордуулжээ. 26-р ишлэлд Хинаан Шээмийн боол болно гэж Нуах зөгнөсөн байна. 27-р ишлэлд Хинаан мөн Эфээтийн ч боол болно гэж Мөшэх бичжээ. Ийнхүү давтан бичсэнээрээ Хинаан ах дүү хоёртоо гарцаагүй эзлэгдэхийг Мөшэх онцолжээ.

Үүнээс гадна эдгээр ишлэлд Шээмийг Хинааны гол ялагч гэж дүрсэлснийг тэмдэглэх нь чухал. 27-р ишлэл дэх: “Эфээт Шээмийн удамтай нэг ам бүлд багтан амьдарч, Хинааны удмыг боол болгосугай” гэснийг: “Эфээт Шээмийн удамтай нэг ам бүлд багтан амьдарснаар Хинааны удмыг боол болгоно” гэвэл илүү дээр орчуулга болох мэт. Эфээтийн удам Шээмийнхтэй хүчээ нэгтгэвэл л Хинааныг хавсран боолчилж чадна гэж Нуах хэлсэн юм шиг санагддаг. Үнэндээ, Хинааныг Шээм манлайлан захирна гэдэгт Мөшэх итгэлтэй байжээ. Тэгэхээр үерийн дараах шинэ эмх журмын урьдчилан таамаглахын аргагүй байсан чухал өвөрмөц онцлогийг Мөшэх энэ хэсэгт дүрсэлснийг бид хардаг. Ирээдүйд хүн төрөлхтөн ихээхэн зөрчилдөж тэмцэлдэх бөгөөд үүнд Шээмийн удмынхан Хинааны удмынхныг ялна гэдгийг тэрбээр ойлгожээ.

Мөшэх Хинааныг болон зөрчлийн сэдвийг онцолсныг үндэс болгон Нуахын хөвгүүдийн түүхээр эртний Израйльчуудад юу ойлгуулах гэснийг үзье.

Хамаарал

Үерийн дараах шинэ эмх журмын тухайх баримтандаа Мөшэх яагаад эдгээр үйл явдлыг багтаасан бэ? Шинэ эмх цэгцийг ийм аргаар дүрслэн үзүүлэх тун онцгой шалтгаан Мөшэхэд байсан юм. Шээм болон Хинаан хоёрын зөрчил түүний Израйль уншигчдын хэрэгцээ шаардлагыг тухай шууд өгүүлэв. Энэ нь тэдний амьдралын амин чухал тал руу хандсан аж.

Мөшэхийн зорилгыг ойлгох гол түлхүүр нь Эхлэлийн 10-р бүлгийн 18, 19-р ишлэлээс харагддаг. Мөшэх Хинааны удмын зарим хүний нэрийг жагсаан

бичсэнийхээ дараа:

Тэдгээр нь Хинаан орны олон олон овог аймгийн өвөг дээдэс болж, тэр олон овог аймгууд ийш тийш нүүдэллэн Цийдун хотоос урагшаа далайн эргийн Газа хотын орчим болох Гираар хүрч, тэндээсээ зүүн тийш Лааш орчмын Цивуум болон Сидом, Гомораах, Адмаах гэдэг хотуудыг бий болгов (Эхлэл 10:18-19).

Арай нарийвчлан бичсэн эдгээр газарзүйн нэрүүд нь Мөшэхийн Израйль уншигчдад танил байв. Хинааны удам угсаа буюу Хинаанчууд нь хойд хэсгийн Цийдун хотоос өмнөд хэсгийн Газа хот, тэндээсээ Сидом, Гомораах хот хүртэлх сунаж тогтсон бүс нутагт суурьшжээ. Мөшэх ялангуяа Амласан газар нутагт суурьшсан Хинааны удмынханы тухай бичсэн. Ертөнцийн Эзэний онцгойлон дуудсан хүмүүс болох Шээмийн удмынхан шиг Израйлийн ард түмэн Хинаанчуудын амьдарч буй энэ нутаг руу нэвтрэн ороод өөрсдийн нутаг орон хэмээн тунхаглах цаг ирлээ.

Тэгэхлээр бид Нуахын хүүхдүүдийн тухай бичсэн Мөшэхийн тэмдэглэлийг өнгөрсөн цагт болсон ямар нэгэн үйл явдлын тухай өгүүлэх гэж зохиомжлон бичээгүй гэдгийг харж байна. Үүнийг балар эртний түүхэнд болох үйл явдлыг Ертөнцийн Эзэн урьдчилан тогтоосон шиг амласан газар руу хөдөлж түүнийг эзлэн авахыг Израйльчуудад уриалсан Мөшэхийн уриалгын цаад утга учрыг харуулахын тулд бичсэн байна. Иймээс Хинаан нутгийг эзлэн авахыг уриалсан Мөшэхийн уриалгыг эсэргүүцэж байгаа Израйльчууд зөвхөн Мөшэхийг эсэргүүцээгүй юм. Тэд үнэндээ Ертөнцийн Эзэний төлөвлөгөөг буюу их усан галавын дараа энэ дэлхийд Түүний тогтоосон шинэ дэг журмыг эсэргүүцсэн юм.

Бид их усан галав болон Нуахын хүүхдүүдийн тухай тэмдэглэл Израйлийн эхний уншигчдын амьдралтай хэрхэн холбогдож байгааг үзлээ. Одоо гуравдахь хэсэг болох Эхлэлийн 11-р бүлгийн 1-ээс 9-д өгүүлэх Бабелийн цамхагийн ажил бүтэлгүйтсэн тухай бичихдээ Мөшэх яг юуны тухай өгүүлэх гэснийг нь үзэцгээе.

БАБЕЛИЙН ЦАМХАГЫН БҮТЭЛГҮЙТЭЛ

Бабелийн цамхаг барих ажил бүтэлгүйтсэн түүхийг Израйльчууд өөрсдийнхөө амьдралтай хэрхэн холбож үзээсэй гэж Мөшэх хүсэж байсныг ойлгохын тулд бид энэ хэсгийн гурван талыг судлах болно. Нэгдүгээрт, тэр хотын тухай Мөшэхийн тодорхойлолт, хоёрдугаарт Яахвэхийн ялалтын тухай түүний тодорхойлолт, гуравдугаарт Амласан газар руу явж байгаа Израйльчуудад энэ нь ямар хамаатай болохыг үзнэ. Эхлээд энэ хотын тодорхойлолтыг үзэцгээе.

Хот

Уг хотын нэр Бабел нь хожим Вавилон гэдэг нэртэй болсон хоттой их төстэй байгааг анзаарах нь чухал. Мөшэхийн үед Вавилон хот нь эртний ойрхи дорнодод их алдартай байв. Энэ хот нь олон зуун жилийн турш соёл иргэншлийн төв болж

байсан бөгөөд нэр хүнд нь үлгэр домгийн хэмжээнд хүрч байлаа. Тиймээс Мөшэх бичсэн номондоо их үерийн дараа Бабел нэртэй газрын тухай бичингүүт энэ газар бол балар эрт цагаас л агуу том хотын төв болж байсан газар юм байна гэдгийг Израйль уншигчид нь шууд мэдсэн байна.

Ялалт

Эхлэлийн 11-р бүлгийн 1-ээс 9-ийн хоёрдахь чухал тал бол эртний энэ агуу хотыг ялсан Яахвэхийн ялалтыг Мөшэхийн дүрсэлж бичсэн байдал юм. Мөшэх энэ түүхийн нилээд олон хэсэгт Бабелийн оршин суугчдын үзэл бодлыг өөрийнхөө жинхэнэ үзэл бодлоор сөргүүлэн тавьж Ертөнцийн Эзэний ялалтын сүр хүчийг дүрслэн үзүүлдэг. Жишээлбэл, “тараах” буюу Еврей хэлний “путс” гэдэг үйл үгээр илэрхийлсэн санааг Мөшэх хэрхэн гаргасныг үзье (ῥῥῥ). Нэг талаар Бабелийн оршин суугчид өөрсдийгөө тал тал тийшээгээ тарж бутарчих вий гэхээс ихэд санаа зовдог байв. 11-р бүлгийн 4-т тэд “тал тал тийш тархаж бутрахгүйн тулд” хот байгуулсан тухай бичсэн байдаг.

Харин ч эсрэгээр нь Мөшэх Бабелийн хүн ардын хүсэхгүй байсан яг тэр зүйлийг Ертөнцийн Эзэн нь хийсэн тухай хоёр удаа бичсэн. 11-р бүлгийн 8-д:

“Мөнхийн Эзэн тэднийг дэлхий даяар тараав” (Эхлэл 11:8).

гэсэн бол 11-р бүлгийн 9-д дахиад л:

“Тэднийг тэндээс Мөнхийн Эзэн бүх дэлхий даяар тараав” (Эхлэл 11:9).

Хуучин Гэрээнд олон удаа “тараах” гэдэг үг нь тулалдаанд бүрэн ялагдсан гэдэг тун таагүй утгыг давхар агуулсан байдаг. Ялагдсан цэргүүдийг дайснууд нь мөрдөн хөөж, зугтааж байхад нь алан хядсаар тараадаг. Энэ түүхэнд ч бас ийм давхар утгаар орсон. Энэ түүхийг Мөшэх “Яахвэхийн хосгүй ялалт” гэж танилцуулдаг. Яахвэх өөрийн ер бусын армийг дуудаж Бабел хотын эсрэг дайтаж, эндхийн зугтааж байгаа оршин суугчдыг нь дэлхий даяар тараадаг.

Бабелийн оршин суугчидтай үзэл бодлоо сөргүүлэн тавьсан Мөшэхийн өөр нэг арга бол уг хот болон тэндхийн цамхагийн хэмжээг авч үзсэн байдал юм. Эхлэлийн 11-р бүлгийн 4-т бичсэнээр бол Бабелийн оршин суугчид бурхдын байдаг газар буюу тэнгэрт тулсан цамхаг барихыг хүссэн байна. Харин энэ санааг нь Мөшэх дооглосон байдаг. Тэгээд тэрээр Эхлэлийн 11-р бүлгийн 5-д:

Мөнхийн Эзэн хүмүүсийн барьж байгаа хот болон цамхагийг үзэхээр бууж иржээ (Эхлэл 11:5).

“Бууж иржээ” гэж энд орчуулсан үгийг Еврей хэлээр “яарад” (ῥῥῥ) гэдэг бөгөөд энэ түүхэнд арай өвөрмөц давхар утгыг агуулдаг. Ертөнцийн Эзэн энэ хотыг зүгээр нэг ажиглаагүй. Түүгээр ч барахгүй Тэрбээр уг хот руу зүгээр ч нэг очоогүй. Бабелийн оршин суугчид тэнгэрт тулсан цамхаг барихыг хүсэж байсан учраас

Яахвэх уг хотыг үзэхийн тулд л тэнгэрийн дээд хэсгээс доош бууж ирсэн юм хэмээн Мөшэх өөрийнхөөрөө зүтгэж бичжээ. Тэгэхлээр Мөшэх Бабелийн оршин суугчдын санаархалыг тохуурхаж байгааг бид харж байна. Үнэндээ Яахвэхийн хувьд энэ хот тун өчүүхэн зүйл билээ.

Эцэст нь Бабелийн цамхагийн ажил бүтэлгүйтсэн нь эртний энэ хотын алдар нэрийг тохуурхахад хэрхэн Мөшэхийг хүргэснийг ажиглах хэрэгтэй. Оршин суугчид нь хотоо Бабел гэж нэрлэдэг байв. Месопотамийн хавийн хэлэнд “бабел” гэдэг үг нь “бурханы үүд” гэсэн утгатай байв. Тэдний барьсан шаталсан хэлбэрийн цамхаг нь үнэндээ бурхадад хүрэх шаттай үүдийг бий болгож, тэд өөрсдөө тэнгэрт орших бурхадын хүч хамгаалалтанд ордог гэсэн сүсэг бишрэлийг нь энэ үг илэрхийлдэг байжээ.

Харин Мөшэх энэ хотын нэрийн талаар өөр үзэл бодолтой байв. Нэгэнт л Яахвэх Бабелийн цамхаг барих ажлыг тэр чигт нь нураасан учраас энэ хот нь бурханы үүд байхаа болсон нь тодорхой болов. Тэгвэл энэ нэр нь ямар утгатай болсон вэ? Мөшэхий илт егөөдсөн хариулт Эхлэлийн 11-р бүлгийн 9-ээс харагддаг. Тэнд:

Мөнхийн Эзэн хүмүүсийн нийтлэг хэлийг ойлгомжгүй болгон бусниулсан учраас хотыг “Бусниулах” гэсэн утга бүхий Бабел гэж нэрлэсэн байна (Эхлэл 11:9).

Бид энэ ишлэлд буй Мөшэхийн егөөдлийг ойлгохын тулд тэрээр хоёр Еврей үгийн дуудлагаар хэрхэн тоглогсныг мэдэх хэрэгтэй. Эхлээд тэр “учраас хотыг ... Бабел гэж нэрлэв” гэсэн. “Бабел” гэдэг үгийг Еврей хэлээр “Баабел” (בָּבֶל) хэмээн энэ газрыг Месопотами хавийнханы нэрлэдэг хэлдэг байв. Дараа нь Мөшэх тэнд “Мөнхийн Эзэн хүмүүсийн нийтлэг хэлийг ойлгомжгүй болгон бусниулсан учраас” хотыг тэгж нэрлэсэн юм гэж тайлбарладаг. “Бусниулах” гэдэг үгийг Еврей хэлээр “бабел” гэдэг үгтэй ойролцоо дуудлагатай “балал” (בָּלָל) гэж хэлдэг байна. Энэ нэрийг Мөшэх ингэж өгөөджээ. Бабел гэж нэрлэсэн жинхэнэ шалтгаан нь тэнд “балал” буюу бусниулах үйл ажил болсон юм хэмээн тэрээр эртний тэр хотыг доромжилсон байна. Тиймээс энэ хот нь бурханы үүд биш харин тэр бол бүх хүнийг бусниулсан газар болсон учраас Мөшэхийн бодлоор бол Бабел гэдэг нэр нь тун тохиромжтой нэр аж. Мөшэх энэ егөөдлөөрөө дамжуулан тухайн үеийн Бабел хотын хосгүй алдар нэрийг нэг мөсөн эргүүлсэн. Тэдний хүндэтгэдэг Ертөнцийн Эзэн Яахвэхийн байгуулсан ялалт балар эртний энэ агуу хотыг доог тохуу болгосон юм хэмээн тэрээр Израйльчуудыг хөөр хөгжөөн болгон инээлгэж байна.

Хотын тухай тодорхойлолт болон Яахвэхийн ялалтыг бодонгоо энэ түүх нь Амласан газрын зүг явж буй Израйлийн ард түмэнд ямар хамаатай болохыг үзэхэд бэлэн боллоо.

Хамаарал

Кадеш-барнеад байхад Мөшэхийн Хинаан нутаг руу явуулсан тагнуулууд муу мэдээтэй ирсэнийг бид мэднэ. Тэд Хинаан орныхон асар том биетэй учир

Израиль үндэстэн тэр нутгийг эзэлж чадахгүй гэж хэлсэн билээ. Үүний улмаас Израйльчууд тэр нутгийг эзлэхээс эргэж буцан дараагийн 40 жил цөл хээрээр хэрэн хэсүүчилсэн байна. Дараагийн үеийнхэн нас бие гүйцэж том болоход л Хинаанчуудын эсрэг дахин нэг удаа Израйльчуудыг хөдөлгөх боломж Мөшэхэд гарсан юм. Бидэнд дээрх муу мэдээний нэг зүйл балар эртний Бабелийн ялагдалын ач холбогдлыг ойлгоход туслах болно. “Дэд хууль” номын 1-р бүлгийн 28-д бичсэнээр тагнуулчид Хинаан нутгийн хотуудын тухай юу гэж хэлснийг сонсоцгооё:

Хүмүүс нь биднээс аварга том, өндөр, хотууд нь маш том, тэнгэр тулсан хэрэмтэй (Дэд хууль 1:28).

Харамсалтай нь орчин үеийн ихэнх орчуулганд Хинааны хотуудын тухай тодорхойлолт болон Бабелийн цамхагийн хоорондын холбоог гаргаж чадаагүй байдаг. Тагнуулчид “тэнгэр тулсан хэрэмтэй” гэж хэлэхэд орсон “тэнгэр” гэдэг үгийг Еврей хэлээр “шамаяим” гэдэг бөгөөд заримдаа “огторгуй” гэж орчуулагддаг. Үнэндээ энэ бол Эхлэлийн 11-р бүлгийн 4-т “тэнгэр тулам өндөр цамхаг” гэж Бабелийн цамхагийн тухай тодорхойлохдоо хэлсэн тэр үг юм. Эдгээр хотууд нь тэнгэр тулам өндөр байсан учраас юунд ялагдашгүй гэдэг нь энэ хоёр тохиолдолд гарч буй гол санаа юм.

Тиймээс л Мөшэх балар эртний Бабел хот болон Хинааны хотуудыг хооронд нь холбосон байна. Бабел хотод цамхаг барьсан хүмүүс тэдний барьсан шаталсан хэлбэртэй энэ цамхаг нь тэнгэрт хүрнэ гэж бодож байсан шиг Израйльчууд Хинааны хотуудын хэрмийг тэнгэр тулам өндөр гэж бодож байлаа. Бабел хотыг Хинааны хотуудтай холбосон энэ холбоо нь Мөшэхийн зорилгыг ил болгож байна. Товчхон хэлэхэд, Израйлын ард түмний өмнө тулгарсан Хинааны хотууд нь тэнгэр тулам өндөр хэрэмтэй боловч, тэд Яахвэхийн хүч чадалтай эн зэрэгцэж чадахгүй билээ. Балар эрт үед хүн төрөлхтөний дунд асар их нэр хүндтэй байсан бөгөөд цамхаг нь тэнгэрт тулна гэж үзэж байсан хотын эсрэг Яахвэх хөдөлсөн юм. Хинаан орны ямар ч хотоос агуу том тэр балар эртний хотыг Яахвэх тун амархан устгасан билээ.

Ертөнцийн Эзэн хүн төрөлхтөнийг эрт цагийн их үерээр чөлөөлж шинэ дэг журамтай болгосон шиг Тэрбээр Израйлийн ард түмнийг Египетээс чөлөөлсөн юм. Ертөнцийн Эзэн Шээм Хинаан хоёрын хоорондын зөрчлийг урдчилан тогтоосон шиг Мөшэх Израйлийн ард түмнийг Хинаанчуудын газар нутаг руу удирдан явсан. Ертөнцийн Эзэн агуу их Бабел хотыг ялан дийлсэн шигээ Тэрбээр удалгүй Хинааны хотуудыг ялах дийлэх ялалтыг Израйлийн ард түмэнд өгөх болно. Балар эртний түүхийн эдгээр бүлгүүдээс Израйлийн ард түмэн Амласан газар руу Мөшэхийг дагаж явах нь зөв чиглэлд явж буй хэрэг гэдгийг Израйлийн ард түмэн ойлгох ёстой байсан юм.

За тэгэхлээр бид Эхлэлийн 6-р бүлгийн 9-ээс 11-р бүлгийн 9 хүртэлх хэсгийн утга зохиолын бүтцийг харлаа. Тэгвэл одоо гуравдахь асуултаа асуухад бэлэн боллоо. Бид энэ материалыг өөрсдийнхөө амьдралд хэрэгжүүлж ямар зарим арга замууд байна вэ?

ОРШИН ҮЕИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Бид сурсанаараа орчин үеийн хэрэгжүүлэлтэнд Христийн хаант улсын гурван үе шатын тухай Шинэ Гэрээний тодорхойлолтоо баримтлан хандах болно. Эхлээд бид чөлөөлөлтийн их үер болон үүний үр дүнд бий болсон шинэ дэг журам Христийн эхний ирэлтээр бий болсон Түүний хаант улсын эхлэлтэй хэрхэн холбогдож байгааг үзэх болно. Дараа нь бид Христэд итгэгчдийн түүхийн туршид Түүний хаан улсын үргэлжлэлтэй эдгээр асуудлын холбоо хамаарал руу хандана. Эцэст нь бид балар эртний түүхийн энэ үе Христ яруу алдраа дуурсган эргэж ирэх үеийн Түүний хаант улсын төгсгөлтэй хэрхэн холбогдож байгааг үзэх болно.

Бид Мөшэхийн бичсэн балар эртний түүхэнд иймэрхүү байдлаар хандах үед Шинэ Гэрээ нь Израйлийн ард түмэнд зориулсан Мөшэхийн анхны зорилгыг Христийн өнгөрсөн, одоо, ирээдүйд хийсэн Христийн ажил болох Түүний хаант улсын гурван үе шаттай холбон өргөжүүлсэн байдлыг бид олж мэддэг. Эхлээд энэ асуудлыг Шинэ Гэрээ Христийн эхний ирэлттэй холбон үзсэн байдлыг харцгаая.

ЭХЛЭЛ

Хаант улсынхаа эхлэлийн үеэр Христ Эхлэлийн 6-р бүлгийн 9-ээс 11-р бүлгийн 9-д Мөшэхийн онцлон бичсэнтэй нийцэхүйцээр өөрийнхөө хүмүүсийг аврах ажлаа амжилттай хийж дуусгасан юм. Бид эдгээр холбоог Христийн зуучилсан гэрээ болон түүний байгуулсан ялалт гэсэн хоёр байдлаар наад зах нь харах болно.

Гэрээ

Нэг талаар Христ Ертөнцийн Эзэний шийтгэлээс аврах гэрээ байгуулан өөрийн хүмүүсийг чөлөөлсөн юм. Нуах Ертөнцийн Эзэнтэй байгуулах гэрээний зуучлагч гэсэн тусгай үүрэг гүйцэтгэж байсаныг бид үзсэн. Мөшэх өөрийн үйлчлэлээ Израйлийн ард түмэнд тайлбарлахын тулд энэ баримтанд олны анхаарлыг хандуулдаг. Яг үүнтэй төстэйгээр Христ энэ дэлхийд ирэхдээ шинэ гэрээг зуучилсан учраас тэр бол бидний чөлөөлөгч юм гэж Шинэ Гэрээ заадаг.

Ертөнцийн Эзэний хүмүүс Түүний шийтгэлийг эдлэвэл зохих үед Христ энэ дэлхий ирсэнийг итгэгчид ихэнхдээ ухаардаггүй. Ертөнцийн Эзэн Хуучин Гэрээний үед гэдэнтэй тогтоосон гэрээг Израйлийн ард түмэн эрээ цээргүйгээр зөрчиж байсан учраас МЭӨ 586 онд Вавилончууд Иерусалим хотыг устгасан юм. Тэр цагаас хойш Израйльчууд харийн ноёрхолоос хэзээ ч бүрэн салж чадаагүй билээ. Харин ирээдүйд Ертөнцийн Эзэн өөрийнхөө хүмүүстэй шинэ гэрээ байгуулан тэднийг хатуу ширүүн цөллөгөөс чөлөөлөх болно хэмээн зарлага Яирмайх зөгнөсөн байдаг. Яирмайхын 31-р бүлгийн 31-д тэрээр:

“Би Израйль болон Иудей аймгийнхантай шинэ гэрээ байгуулах цаг удахгүй ирэх болно” хэмээн Мөнхийн Эзэн ингэж айлдаж байна” (Яирмайх 31:31).

Энэ шинэ гэрээний зуучлагч болж Есүс энэ дэлхийд ирсэн гэдгийг Христэд итгэгч ихэнх хүн мэднэ. Дагалдагчидтайгаа барьсан сүүлчийн зоогийн үеэр Есүс энэ үүргээ өөрөө хүлээн зөвшөөрсөн байдаг. Луухын 22-р бүлгийн 20-д тэрбээр:

Энэ дарс миний цустай адил. Та нарын төлөө асгарах миний цус бол Ертөнцийн Эзэн ба хүн төрөлхтөний хооронд тогтоосон шинэ гэрээний баталгаа юм (Луух 22:20).

Нуух Ертөнцийн Эзэнтэй тогтоосон гэрээний зуучлагч болж хүмүүсийг Түүний шийтгэлээс чөлөөлсөн. Есүс бас түүнтэй адил, Хаант улсынхаа эхлэлээр загалмай дээр асгаруулсан цусаараа байгуулсан шинэ гэрээгээр зуучлан өөрт нь итгэсэн хүмүүсийг Ертөнцийн Эзэний шийтгэлээс чөлөөлсөн юм байна гэдгийг бид үзлээ.

Ялалт

Есүс Шинэ гэрээ байгуулахаас гадна газар дэлхий дээр хийсэн түүний үйлчлэл нь ер бусын ариун дайныг ялалтанд хүргэсэн юм. Мөшөх их усан галавын дараах дэлхий дээр тогтох шинэ эмх цэгцийн нэг хэсэг болгож ариун дайн гэдэг ойлголтонд анхаарлаа хандуулсан байдаг. Тэрээр дэлхий дээр тогтох энэ шинэ эмх цэгц нь Израйлийн ард түмнээс Хинаан орныг эзлэхээр урагш хөдлөхийг шаардаж байгааг тогтоож, улмаар тэдэнд агуу их ялалтын баталгааг өгч байна. Үүнийг харьцуулахын тулд Пууль Холосасын 2-р бүлгийн 15-д Хаант улсынхаа эхлэлийн үеэр хийсэн Христийн ялалтыг хэрхэн дүрсэлснийг үзэцгээе. Тэнд:

Ертөнцийн Эзэн-эцэг тэр үед Есүс Христээр ер бусын ертөнцийн хорон муу хүчит эрх баригч, хүчтэнгүүдийг ялан дийлүүлж, эрх тушаалаас нь зайлуулж энэ тухай бүх ертөнцөд зарлан тунхаглав (Холосас 2:15).

Энд бичсэнээр бол эхний ирэлтийнхээ үеэр хийсэн Есүсийн ялалт нь улс төрийн бус, сүнсний дайны ялалт байна. Есүсийн үхэл болон дахин амилалт нь тэр үед энэ дэлхийг захирч байсан ер бусын ертөнцийн хорон муу эрх баригч, хүчтэнгүүдийг ялагдлын эхийг тавьсан юм. Амиараа өргөл болж өөрийнхөө хүмүүсийг чөлөөлсөн нь олон түмний нүдэн дээр балар эртний Бабел болон хожим нь Хинааны агуу хотуудыг устгасан Яахвэхийн ажилтай их адил байна.

Энэ утгаар бол Есүс зөвхөн шинэ гэрээгээрээ өөртөө итгэсэн хүмүүсийг чөлөөлснөөс гадна өөрийн үхэл болон дахин амилалтаар муу ёрын сүнсний хүч чадлыг ялан дийлсэн юм. Христийг дагагчид газар дэлхий дээрх Христийн үйлчлэлийг Эхлэл номон дээр олон зуун жилийн өмнө амласан эцсийн ялалтын эхлэл гэж үзсэн.

Эхлэлийн 6-р бүлгийн 9-ээс 11-р бүлгийн 9-д гарч буй санаа нь зөвхөн Христийн эхний ирэлттэй холбоотой болохыг л Шинэ Гэрээ заадаг гэж бид үзэж болохгүй. Энэ хэсэг нь бас Христийн хаант улсын үргэлжлэл буюу бидний одоогийн

амьдарч буй үетэй холбоотой байдаг.

ҮРГЭЛЖЛЭЛ

Христийн эхний болон хоёрдахь ирэлтийн хоорондох үеийг Мөшэхийн бичсэн балар эртний түүхийн сүүлчийн бүлэгтэй үгүй дээ л хоёр байдлаар холбогдсон тухай Шинэ Гэрээ тодорхойлсон байдаг. Энэ хоёр хэтийн төлөв нь Христэд итгэгч хүний амьдралд гүйцэтгэх усан баталгааны ач холбогдол болон ер бусын сүнслэг дайнтай шууд холбогддог. Энэ үед Христэд итгэгч хүний амьдралаар амьдарч байгаа бид Нуахын усан галавын утга учир болон энэ усан галавын дараа дэлхий дээр тогтсон шинэ эмх цэгцтэй зайлшгүй тулгардаг.

Усан баталгаа

Ялагуяа Шинэ Гэрээний нэг хэсэг усан баталгаа хийлгэхийг Нуахын үеийн чөлөөлөлтийн их үертэй холбож бичсэн байдаг. 1 Петрийн 3-р бүлгийн 20-иос 22-т төлөөлөгч Пууль юу гэж бичсэнийг сонсоцгооё:

Нуах онгоц барих удаан хугацааны турш Ертөнцийн Эзэн хүн төрөлхтөнд өөрийн үгийг дагах бололцоог тавьж өгсөн. Гэвч зөвхөн түүний гэр бүлийн найман хүн тэр усаар дамжин аврагдав. Энэ нь таныг бас аварсан усан баталгааг бэлгэдэж байгаа юм. Гэхдээ энэ нь зөвхөн нэг ёслол хийж биеэ угаалгана гэсэн үг биш харин Ертөнцийн Эзэнээс зөв сэтгэлээр авралыг хүснэ гэсэн утгатай. Есүс Христийг Ертөнцийн Эзэн дахин амилуулаад одоо ер бусын ертөнцдөө оруулж, баруун гарынхаа хүндэт суудалд суулган, ер бусын элч, тэдний эрх баригчид болон ер бусын ертөнцийг бүхэлд нь захируулж байна (1 Петр 3:20-22).

Энэ гайхалтай хэсэгт Петр Христийн хаант улсын үргэлжлэлийн үеэр авралд хандах хүн бүрийн хандлагыг Нуахын үеийн их үертэй шууд холбосон байна. Тэр Нуах болон түүний гэр бүлийг их усаар дамжин аврагдсан гэдэг дээр анхаарлаа тавин энэ хэсгийг эхлэж байна. Усаар дамжин ирсэн чөлөөлөлт нь хүн төрөлхтөнд Ертөнцийн Эзэний хамгаалалтанд орж шинэчлэгдсэн дэлхийд орох замыг нээсэн юм.

Түүнээс гадна тэрээр усан баталгаа дээр онцгойлон анхааран Нуахын үеийн их үерийн ус Христэд итгэгч хүний амьдралын хоорондын харилцаа руу шууд хандсан байна. Нуахын үеийн их ус нь Христэд итгэгч хүний усан баталгааг бэлэгдсэн юм хэмээн тэр хэлж байна. Нуахын үеийн их ус нь аймшигтай муухай гэмт явдлаар дүүрсэн дэлхийг угааж цэвэрлэн шинэ эхлэлийн замыг нээсэн шиг Улаан тэнгисээр Мөшэхийн гарсан явдал нь Израйль үндэстнийг Египетийн харгислалаас салгаж шинэ эхлэл рүү аваачсан гэдгийг бид энэ хичээлээр үзсэн. Үүнтэй адил, усан баталгаа хийлгэх нь итгэгчдийн гэмийг угааж, тэдэнд Христтэй нэгдмэл мөнхийн

амьдралын эхлэлийг өгдөг юм.

1 Петрийн 3-ийн 21-д усан баталгаа нь зөвхөн Ертөнцийн Эзэнд үнэн сэтгэлээсээ итгэсэн хүнийг л авардаг тухай өгүүлсэнийг бид ойлгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл зөвхөн усан баталгаа хийлгэж усаар угаалгах нь хэнийг ч аврахгүй. Зөвхөн Христэд итгэж гэмээ уучлуулж цэвэрлүүлсэн хүн өөрийн хүсэлтээр хийлгэсэн усан баталгаа л тухайн хүнийг авардаг гэдгийг бэлэгдэн харуулсан байна. Шинэ Гэрээ нь Христ л намайг аврана гэсэн итгэлээр Түүнд хандсан хүн бүр их үерээр дамжин шинэ дэлхийд ирсэн Нуах шиг усан баталгаагаар дамжин цэвэрлэгдэн шинэ амьдралд ордог болохыг нотлосноор Нуахын үеийн чөлөөлөлтийн их үерийг Христийн хаант улстай холбодог юм.

Сүнслэг дайн

Нуахын их үер нь хүн төрөлхтөнийг ер бусын ариун дайнаас чөлөөлсөн гэдгийг Мөшэхийн бичсэн балар эртний түүх үзүүлж байгааг бид харлаа. Энэ шинэ эмх цэгцийг дагахын тулд Хинаан нутгийг эзлэхээр хөдлөх Израйльчуудыг зоригжуулахын тулд Мөшэх эхлээд энэ баримт руу анхаарлаа хандуулсан юм. Яг үүнтэй адил Шинэ Гэрээнд, итгэгч хүн бүрт тулгарах сүнсний тулалдааныг дүрслэхийн тулд энэ сургаалыг Христийн хаант улсын үргэлжлэлтэй холбосон байдаг. Энэ асуудлыг Пууль Эфесийн 6-ийн 11, 12-т хэрхэн хэлсэнийг сонсоцгооё:

Адгийн муу ёрын сүнсний заль мэхийг эсэргүүцэн давахын тулд Ертөнцийн Эзэний өгсөн ер бусын хуяг дуулгыг хэрэглэ! Учир нь, бидний дайсан бол хүн төрөлхтөн биш, харин дээд тушаалт ер бусын эрх баригч, засаг захиргаа буюу Ертөнцийн Эзэнийг эсэргүүцэгч балар харанхуй дэлхийг захирагч хүч чадал ихтэй муу ёрын сүнс юм (Эфес 6:11-12).

Шинэ Гэрээний энэ болон бусад ишлэлд өнөө үед Христэд итгэгчид адгийн муу ёрын сүнстэй дайн хийж байгаа тухай тодорхой заадаг. Харамсалтай нь өнөө үед Христэд итгэгч олон хүн Мөшэхийг дагаж байсан Израйльчууд Хинаан нутгийг эзлэхээс зайлсхийж байсан шиг энэ бүхнийг өөрсдийнхөө сүнсний ер бусын амьдралын нэг тал гэж хүлээж авдаггүй. Харин энэ талаарх Шинэ Гэрээний байр суурь тодорхой билээ. Бид энэ сүнсний тулалдаанд оролцох ёстой.

Яг л Эфесийн 6-ийн 13-д Пуулийн хэлсэн шиг:

Тиймээс ёрын муу хүчтэй тулгарч хүнд зовлонд орохдоо Ертөнцийн Эзэний ер бусын хамгаалалтыг авсан цагт л бүгдийг даван туулж чадна (Эфес 6:13).

Хэрэв бид Ертөнцийн Эзэний ер бусын хамгаалалтыг авч чадвал, сүнсний тулалдаан ялан дийлэх болно.

Тэгэхлээр Шинэ Гэрээнд их үерээр дамжсан Нуахын чөлөөлөлтийг, усан баталгаагаар дамжсан чөлөөлөлттэй маань холбосон байдгийг бид харлаа. Балар эртний дэлхий нь дайн тулалдаанд хүрсэн шиг Христэд итгэгч хүний усан баталгаа

нь биднийг өдөр бүр ер бусын сүнсний тулалдаанд татан оролцуулдаг гэж Шинэ Гэрээ бас заадаг юм.

ТӨГСГӨЛ

Шинэ Гэрээ нь балар эртний түүхийн тухай өгүүлсэн хэсгийн сүүлчийн бүлгүүдийг Христийн хаант улсын эхлэл, үргэлжлэлтэй холбосон байдгийг ойлгосон цагт Түүний хаант улсын төгсгөлийг Нуахын үер болон эртний шинэ эмх цэгцийг тогтоох дайнтай бас холбосон байдгийг олж мэдэхэд гайхах зүйлгүй билээ.

Сүүлчийн эрс эргэлт

Шинэ Гэрээний зохиогчид дээрх холбоосыг яруу алдраа дуурсган эргэж ирэх Христийн ирэлтийг эцсийн эрс эргэлт авчрах эцсийн тулалдаан шиг дүрслэн гаргасан байдаг. Бид 2 Петрийн 3-р бүлэгт Нуахын үеийн эртний үерийг яруу алдраа дуурсган ирэх Христийн ирэлттэй илэрхий холбосон байгааг олж мэддэг. Энэ тухай Петр 3-аас 6-р ишлэлд юу гэж хэлж байгааг сонсьё.

Та нар нэг чухал юмыг ойлгох хэрэгтэй. Дэлхий сөнөж Есүс Христ дахин ирэхээс өмнө тохуурхах дуртай олон хүн бидний сургаалыг доромжлохын тулд ‘Есүс Христ энэ дэлхийд дахин ирнэ гэсэн чинь яасан бэ? Есүсийн үеийн хүмүүс нас барснаас хойш одоо болтол юу ч болсонгүй. Орчлон ертөнц бий болсноос хойш хорвоо дэлхий огтхон ч өөрчлөгдсөнгүй хэвээрээ байна гэж хэлнэ’ Тэд нэгэн эрхэм чухал юмыг зориуд үл тоомсорлож байна. Өнө эрт Ертөнцийн Эзэн тэнгэрийн бүх эрхэс болон орчлон ертөнцийг бүтээж, дэлхийг бүрхсэн их уснаас хуурай газрыг бий болгосноос хойш байгаль, дэлхий ба хүн амьтан усны хүчээр амьдардаг атал хожим Ертөнцийн Эзэн өөрөө Нуах гэгч хүний үед дэлхийн тэр их усыг гэнэт үер болгон бүгдийг устгажээ (2 Петр 3:3-6).

Энэ хэсэгт Петр орчлон хорвоогийн нэгэн хэвийн байдал Есүс эргэж ирэхгүйн баталгаа гэж үзэж байсан дохуурхагчдын бодлыг засаж залруулж байна. Тэд орчлон ертөнц бий болсон цагаас хойш бүх зүйл нэг хэвийн байгаа гэж боддог. Энэ бүгдийг Ертөнцийн Эзэн бүтээснээс хойш юу ч задарч өөрчлөгдөөгүй аж. Нэгэнт юу ч өөрчлөгдөөгүйгээс хойш, ирээдүйд ямар нэгэн юм болохгүй гэж тэд боддог байжээ.

Харин энэ бүхний Петр өөр аргаар батлахын тулд Нуахын үеийн их үерийн тухай Мөшэхийн тэмдэглэл рүү ханджээ. Бүр эхэнд Ертөнцийн Эзэн хорвоо дэлхийг уснаас салгаж бүтээсэн боловч Нуахын үед энэ дэлхийг их үерээр устгасан. Энэ дэлхийн түүхэнд асар том өөрчлөлт гарсан юм. Нуахын үед Ертөнцийн Эзэн хөндлөнгөөс оролцож дэлхийг устгасан билээ. Одоо 2 Петрийн 3-р бүлгийн 7-д буй Петрийн дүгнэлийг сонсоцгооё:

Үүний адилаар Ертөнцийн Эзэн хожмын нэгэн цагт орчлон ертөнцийг гэнэт шатаах болно. Хүн төрөлхтөнийг шүүж, өөрийнх нь үгийг дагаагүй хүмүүсийг мөнхийн зовлонд оруулах болно (2 Петр 3:7).

Нэг үгээр балар эртний дэлхий нь их үерийн улмаас сүйрсэн шиг өнөөгийн дэлхий ертөнц нь бүхнийг шүүхээр дахин ирэх Христийн ирэлтээр төгсгөл болно гэж Петр батлаж байна. Харин энэ удаа усаар бус харин галаар шийтгэнэ. Ертөнцийн Эзэн эцсийн удаа хүн төрөлхтөний гэмийн эсрэг хөдлөхөөр шийдэх тэр мөчид эртний тэр их үер шиг томоохон хэмжээний сүйрэл болно гэдэгт бид итгэлтэй байж болно.

Ийм байдлаар Шинэ Гэрээ бидэнд Нуахын үеийн их үертэй Христийн дахин ирэлтийг холбож харахыг зааж байна. Нуахын үед асар том өөрчлөлт гарч гэмт муу хүмүүсийг газрын хөрснөөс арчиж хаясан билээ. Харин Христийг яруу алдраа дуурьсган эргэж ирэхэд үүнээс ч агуу сүйрэл болно. Тэр үед бидний мэдэх энэ дэлхий маань бүрмөсөн задарч, эрс өөрчлөлт гарах болно. Гэмт муу хүмүүс газрын хөрснөөс арчигдаж, Христийг дагаж байсан хүмүүс мөнхөд сүр жавхлантайгаар орших шинэ дэлхийд орох болно.

Сүүлчийн тулалдаан

Гэхдээ Нуахын их үерийн тухай өгүүлсэн балар эртний түүхэнд ч гэсэн Ертөнцийн Эзэний хүмүүс болон Түүний дайснуудын хоорондох зөрчил тэмцэл, дайн тулалдаан дагалдаж гарч байгааг бид харлаа. Үүнтэй адил Шинэ Гэрээнд бас Христийн дахин ирэлтийг дагалдаж эцсийн асар том тулалдаан болох тухай тодорхой өгүүлдэг. Төлөөлөгч Иоган Үзэгдэл номын 19-р бүлгийн 11-ээс 16-д Христийн дахин ирэлтийн тухай юу гэж бичсэнийг сонсоцгооё:

Надад Ертөнцийн Эзэний орших газар үзэгдэж, тэнд нэгэн цагаан морьтон байгааг би харлаа. Тэр бол үнэнч шударга, бүрэн төгс найдвартай Есүс Христ бөгөөд дэлхийн ард түмнийг шүүн шийтгэж, тэдний эсрэг шударга дайн хийх гэж байна. Нүд нь гал дөл шиг цогтой, толгой дээр нь олон титэмтэй аж. Титмүүд дээр нэр бичээстэй, гэвч Есүс Христээс өөр хэн ч тэр нэрийн утгыг сайн ойлгохгүй ажээ. Хувцас нь цусанд будагджээ. Хүмүүс Есүс Христийг ‘Ертөнцийн Эзэн ба хүн төрөлхтөний хооронд зуучлагч’ гэж нэрлэдэг. Миний үзэгдэлд Ертөнцийн Эзэний хүмүүс цав цагаан хувцас өмсөж, цагаан морьд унаж, Есүс Христийн хойноос цэрэг шиг дагаж байлаа. Есүс Христийн амнаас маш хурц сэлэм цухуйж байв. Тэрбээр үг хэлж өөрийнхөө эсрэг бүх улсын ард түмнийг дийлэх болно. Дараа нь хүн төрөлхтөнийг төмөр таягтай хүн мэт хатуу чанд шүүж, Ертөнцийн Эзэний эсрэг хүмүүсийг нэгмөсөн шийтгэнэ. Тэгж шийтгэх нь хүн усан үзмийг хөлөөр шахаж, дарс гаргахын адил юм. Үзэм шахах газар бол энэ Ертөнцийн туйлын эрх чадалтай их Эзэний уур хилэнгээс гарах шийтгэлийн бэлэг тэмдэг ажээ. ‘Ямар ч эзэн, хаан, эрх баригч, засаг төртэй зүйрлэшгүй дээд эрхтэй’ гэсэн бичиг Есүс Христийн дээлийн

хормой дээр харагдана (Үзэгдэл 19:11-16).

Иоган энэ дэлхийн төгсгөлийн үед болох үйл явдлыг харуулсан үзэгдлийг сонирхол татам үгээр дүрслэхдээ, Христийн эргэж ирэх үйл явдал бол Христ өөрөө оролцож бүх дайснаа устгах дэлхий нийтийг хамарсан тулалдаан байх болно гэж тунхаглаж байна. Тэгээд авралынхаа төлөө Христэд найдсан хүмүүст агуу их мөнхийн ялалт нь ирж, харин түүнээс татгалзсан хүмүүст шийтгэл сүйрэл ирэх болно.

Тэгэхлээр бид Шинэ Гэрээнд Христийн хаант улсын төгсгөлийг адгийн муу ёрын сүнсний эсрэг хийсэн Ертөнцийн Эзэний дайны бүрэн биелэл шиг танилцуулдгийг харлаа. Өөрийнхөө бүх дайсны эсрэг Христийн хаант улсыг бий болгоход Ертөнцийн Эзэн тууштай хэвээр байна. Христийг яруу алдраа дуурьсган эргэж ирэх үед энэ ер бусын агуу зорилгыг бид бүрэн ухаарах болно. Гэмт муу хүмүүс устаж үгүй болно. Христэй нэгдмэл Ертөнцийн Эзэний хүмүүс шинэ дэлхий ертөнцөд мөнхийн ялалт, баяр хөөрийг эдлэх болно.

ДҮГНЭЛТ

Энэ хичээлээр бид Эхлэлийн 6-р бүлгийн 9-ээс 11-р бүлгийн 9 хүртэлх хэсгийг судаллаа. Бичээсийн энэ хэсэгт Мөшэх өөрийнх нь удирдлага дор Амласан газар руу явж буй Израйлийн ард түмэнд явах ёстой зөв чиглэлийг харуулсан байна. Бид энэ хэсгийн утга зохиолын бүтцийг үзсэн. Энэ хэсгийг Мөшэх Хинааныг эзлэн авахаар бат итгэлтэйгээр урагшлахад нь Израйльчуудыг зоригжуулахын тулд хэрхэн зохиомжлон бичсэнийг бид үзсэн. Бид бас энэ сэдвийг Шинэ Гэрээ Христийн хаант улсын гурван үе шаттай хэрхэн холбосныг харсан.

Улам бүр мөхөж буй энэ дэлхийд Христийн төлөө амьдрахад маань бидэнд тулгарах бэрхшээл, хүнд хэцүү үед бид бүхэн олон жилийн өмнө Израйлийн ард түмэнд Мөшэхийн өгсөн энэ үгийг үргэлж санаж байх хэрэгтэй. Христэй нэгдсэн биднийг Ертөнцийн Эзэн Нуахаар дамжуулан эртний хүмүүсийг аварсан шигээ гэмийн дарлалаас чөлөөлсөн юм. Өөрийнхөө хүмүүст Христийн авчрах төгс ялалтын өдрийг хүлээж байхад маань тулгарах зөрчил тэмцлийн үед бидэнд шаардлагатай замыг ч хүртэл тэрбээр зааж өгсөн юм. Тэр цагийг хүртэл одоогийн бидний амьдарч буй энэ дэлхий маань төгс бус хэвээр л байх болно гэдгийг бид мэднэ. Хүн төрөлхтөний төлөө хийж Христийн ер бусын тулалдаанд оролцож Түүнийг дагах нь зөв чиглэл гэдэгт бид итгэлтэй байж болно.

Dr. Ричард Л. Прагг. (Host) is Co-Founder and President of Third Millennium Ministries. He served as Professor of Old Testament at Reformed Theological Seminary for more than 20 years and was chair of the Old Testament department. An ordained minister, Dr. Pratt travels extensively to evangelize and teach. He studied at Westminster Theological Seminary, received his M.Div. from Union Theological Seminary, and earned his Th.D. in Old Testament Studies from Harvard University. Dr. Pratt is the general editor of the NIV Spirit of the Reformation Study Bible and a translator for the New Living Translation. He has also authored numerous articles and books, including *Pray with Your Eyes Open*, *Every Thought Captive*, *Designed for Dignity*, *He Gave Us Stories*, *Commentary on 1 & 2 Chronicles* and *Commentary on 1 & 2 Corinthians*.

ҮГСИЙН ТАЙЛБАР

усан онгоц (ark) – Нуахын барьсан усан онгоцыг ингэж нэрлэдэг. Мөн Мөшэхийг хэвтүүлэн усанд тавьсан сагсыг энэ үгээр илэрхийлсэн байдаг

Вавилон (Babel) – Хүмүүс тэнгэрт хүрэх цамхаг барихаар шийдсэн хот. Месопотами хэлээр “Бурханы хаалга” гэсэн утгатай үг

балал (balal) – “будилаан” гэсэн утгатай Еврей үг. Вавилоны цамхагийг барьсан хүмүүсийг Ертөнцийн Эзэн харааж хэлийг нь будилуулсан үйл явдлыг энэ үгээр илэрхийлсэн байдаг

Хинаан (Canaan) – Хамийн хүү. Түүний үр удам нь Шэм, Эфээт нарын үр удамд үйлчилэх болно гэсэн үг байдаг

Эрс тэсрэлт (cataclysm) – Улстөр, нийгэм, газарзүйд бий болдог гэнэтийн хүчтэй өөрчлөлт

бүрэн төгс ялах үе (consummation) – Христ эргэн ирж, түүхэн дэх Бурханы туйлын зорилгыг биелүүлэх тэрхүү эцсийн үеийн эхлэлийн гурав дахь буюу эцсийн үе шат

үргэлжлэх үе (continuation) – Эцсийн үеийн эхлэлийн хоёр дахь буюу дунд шат. Энэ нь Христийн анхны ирэлтээс хойших, эцсийн ялалтаас өмнөх Бурханы хаанчлалын үе

гэрээ (covenant) – Хоёр хүн эсвэл бүлэг хүмүүсийн хооронд, мөн Бурхан аливаа хүн ба бүлэг хүмүүстэй байгуулсан заавал биелүүлэх үүрэг бүхий хууль ёсны хэлцэл

Хам (Ham) – Нуахын хүү. Аавыгаа согтуу хэвтэж байхад нь шоолж доромжилсон. Түүний үр удам хойд африк болон Хинаан нутгаар тархсан. Түүний хүү Хинаан нь Ертөнцийн Эзэний хараалыг хүртсэн

Эхлэлийн үе (inauguration) – Эцсийн юмсын эхний үе шат. Энэ нь Христийн эхний ирэлт болон Түүний элч нар ба эш үзүүлэгчдийн үйлчлэлийг хэлдэг

Эфээт (Japheth) – Нуахын хөвгүүдийн нэг. Тэрээр аавдаа хүндэтгэлтэй хандсан. Тэрээр их ерөөгдөж, Хинааны үр удам түүний үр удамд үйлчлэх болно гэсэн үг бий. Түүний үр сад Хинааны хойд хэсгээр суурьшсан

Ламех (Lamech) – Хаяаны ихэрхүү бардам үр сад. Өөрийг нь шархдуулсан залууг алсан хэмээн сайрхаж байсан

шамаяим (shamayim) – “тэнгэр, тэнгэрүүд” “огторгуй” гэсэн утгатай Еврей үг